Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд татварын орлогын болон зээлийн авлагын мэдээ тайлан гаргалттай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Саранчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн 01/57 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг дарга Орон нутагтаа бүх шатны хурлын шийдвэр Засгийн газар, аймаг, сумын стратеги зорилт, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж, төр, засгийн бодлого шийдвэрийг иргэдэд сурталчлан таниулж, иргэдийн амар тайван, аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлж, байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг цогцлоон төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй, хариуцлагатай байдлыг төлөвшүүлж, сумын эдийн засгийн чадамжийг сайжруулан өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг, аймгийн Засаг даргын харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө бага байна.

Баянчандмань сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй, нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцүүлэн Сангийн сайдын 2006 оны 388, 2015 оны 341 тоот тушаалаар баталсан загвар, аргачлалыг баримтлан тайлагнаж байна.

Сумын дотоод хяналтын ажлын хэсгийг 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/240 дугаар захирамжаар 5 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулж, төсвийн 6 байгууллагын өр, авлага, эргэлтийн хөрөнгөд тооллого хийсэн байна. Аймгийн Засаг даргаас жилд 2 удаа бүх сум байгууллагад нэрэмжит үзлэг, Санхүүгийн хяналт аудитын алба удирдамж төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт явуулдаг, байгууллага бүрд дотоод хяналтын нэгж ажилладаг боловч сумын хэмжээнд төсөв санхүүгийн сахилга бат сайжирч, алдаа зөрчил буурахгүй байна. Цаашид эрсдэлд суурилан дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын

гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянчандмань сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг суурь үзүүлэлтийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний нийт орлого 5,825,627.0 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 87,384.3 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75,0 хувиар буюу 65,538.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд дахин тооцох шаардлагатай байна.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 4,304,066.8 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 64,561.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Энэ нь төлөвлөлтийн үе шатнаас 22,823.3 мянган төгрөгөөр буурсан байна. Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75,0 хувиар буюу 48,420.7 мянган төгрөгөөр тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг дарга нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ЗЗНДНТУТХ, Шилэн дансны тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хууль болон холбогдох бусад хууль дүрэм зааврыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсөвт байгууллага, төрийн сан, Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, эмийн эргэлтийн сан, Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан зэрэг 11 санхүүгийн тайланг нэгтгэн тайлагнасан байна.

Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд Сангийн яамны Э тайлангийн нэгтгэлийн систем программыг ашиглаж байна.

Орлогын талаар:

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн орлого 519,691.2 мянган төгрөг, аймгаас санхүүгийн дэмжлэг 385,967.8 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сан 96,326.5 мянган төгрөг, тусгай зориулалтын шилжүүлэг 2,057,141.7 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгал 13,070.8 мянган төгрөгийн санхүүжилт, эмийн эргэлтийн сангийн борлуулалтын орлого 82,044.1 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд 353,641.6 мянган төгрөг, СХС-ийн эргэн төлөлт 205,797.3 мянган төгрөг, нийт 3,713,690.0 мянган төгрөгийн орлого, эх үүсвэрийг төвлөрүүлэн, зарцуулсан байна.

Баянчандмань сумын ИТХ-ын Хуралдааны 2021 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг 163,797.0 мянган төгрөг, татварын бус орлогыг 261,050.0 мянган төгрөг, нийт 424,847.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Орон нутгийн төсөвт 2021 онд татварын орлого 222,798.4 мянган төгрөг, татварын бус орлого 296,892.8 мянган төгрөг, нийт 519,691.2 мянган төгрөг төвлөрч, батлагдсан төлөвлөгөөг 95,094.2 мянган төгрөг буюу 122,4 хувиар биелүүлсэн байна. Орон нутгийн орлогын төлөвлөгөө өндөр хувиар биелэхэд үл хөдлөх хөрөнгийн албан татвар 4,6 дахин буюу 25,566.8 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн нь иргэд өмчилсөн газраа эдийн засгийн эргэлтэд оруулсан, 2021 онд малын тоо толгойн татварыг сумын ИТХ тогтоож баталсантай холбоотой 11,073.0 мянган төгрөг, хүү торгуулийн орлого 38,166.6 мянган төгрөгөөр биелүүлсэн нь торгуулийн мэдээлэл е баримтаар очсоноор цахим төлөлт сайжирсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд 12,699.3 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 401,883.1 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор нийт 414,582.3 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн ба 20,220.9 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан байна.

Бараа материалын дансанд худалдан авсан 439,193.9 мянган төгрөгийн, үнэ төлбөргүй хүлээн авсан 309,683.5 мянган төгрөгийн, шилжүүлэн авсан 915.0 мянган төгрөгийн, нийт 749,792.4 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 674,832.3 мянган төгрөгийн бараа материалыг хассан байна.

Авлага, өглөгийн талаар:

Санхүүгийн нэгтгэсэн тайланд байгууллагаас авах 172,651.1 мянган төгрөг, хувь хүмүүсээс авах 296,894.7 мянган төгрөг, зээлийн хүүгийн авлага 6,725.5 мянган төгрөг, ажиллагчидтай холбоотой авлага 55.5 мянган төгрөг нийт 476,326.8 мянган төгрөгийн авлага нэгтгэгдсэн байна. Нийт авлагын 344,518.3 мянган төгрөг буюу 72,3 хувийг сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага, 74,039.2 мянган төгрөг буюу 15,5 хувийг ЭМТ-ийн авлага эзэлж байна.

Бараа үйлчилгээний зардлын өглөг 7,546.2 мянган төгрөг, байгууллагад төлөх 19,395.8 мянган төгрөг, хувь хүмүүст төлөх 527.7 мянган төгрөг, нийт 27,469.7 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй нэгтгэгдсэн байна. Нийт өрийн 25,887.7 мянган төгрөг буюу 94.2 хувийг ЭМТ-ийн өр эзэлж байна.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн харилцах дансанд 299,437.6 мянган төгрөг, арилжааны банк дахь харилцах дансанд 1,217.4 мянган төгрөг, нийт 300,655.0 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна.

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Бараа материал 457,510.9 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 5,966,781.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	159,407.9	300,655.0	141,247.1
Авлага	405,168.8	476,326.8	71,158.0
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	382,550.9	457,510.9	74,960.0
Нөөцийн бараа /сурах бичиг/	-	-	-
Үндсэн хөрөнгө	6,039,455.1	5,966,781.8	(72,673.3)
Нийт хөрөнгө	6,986,582.7	7,201,274.4	214,691.8
Өр төлбөр	71,173.1	27,469.7	(43,703.3)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6,915,409.6	7,173,804.7	258,395.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,986,582.7	7,201,274.4	214,691.8

Бараа материалын дансны үлдэгдэл 457,510.9 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 74,960. мянган төгрөгөөр өссөн нь эм, боох материал, аж ахуйн материал, бусад хангамжийн материалын үлдэгдэл өмнөх оноос өссөнөөс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,966,781.8 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 414,582.3 мянган төгрөг нэмэгдэж 20,220.9 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан байна. Нэмэгдсэн үндсэн хөрөнгө нь үнэ төлбөргүй хүлээн авсан 401,883.0 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөрх худалдан авсан 12,699.3 мянган төгрөг байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ЕБС-д дээврийн засвар 180,000.0 мянган төгрөг, гал тогооны тоног төхөөрөмж 23,505.6 мянган төгрөг, Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар ЗДТГ-т 98,560.3 мянган төгрөг, ОНХС-ийн хөрөнгөөр 75,151.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,201,274.4 мянган төгрөг болж 214,691.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 231,535.2 мянган төгрөг, өмнөх оны үр дүнд ЕБС 27,722.9 мянган төгрөгийн авлагыг шүүхийн шийдвэрээр бүртгэснээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сумын 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 3,713,409.8 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний зардалд болон хөрөнгийн зардалд зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Баянчандмань сумын ИТХ-ын Хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 18-ний өдрийн “2021 оны төсөв батлах тухай” 02 дугаар тогтоолоор 2021 онд төсөвт төвлөрүүлэх татварын ба татварын бус орлогыг 424,847.0 мянган төгрөгөөр, зарлагын нийт хэмжээг 2,979,355.9 мянган төгрөгөөр баталсан байна. Сумын ИТХ-ын Хуралдааны 2021 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор 2021 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг

3,110,031.8 мянган төгрөгөөр тодотгон баталсан ба сум хөгжүүлэх сангийн орлогыг 166,000.0 мянган төгрөгөөр, нийт 3,276,031.8 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Төсвийн захирагчийн 2021 оны төсвийн төслөөс 437,378.0 мянган төгрөгөөр бууруулан санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайланд 7 хөтөлбөр 20 арга хэмжээнд зориулан нийт 3,276,031.8 мянган төгрөг төсөвлөгдсөн. Энэ нь сумын ИТХ-ын хуралдааны тогтоолоор төлөвлөгөө нийт 3,239,510.7 мянган төгрөгөөр тайлагнасан нь ИТХ-ын батлагдсан төлөвлөгөөнөөс ЕБС 19,343.1 мянган төгрөгөөр илүү, Эрүүл мэндийн төв 55,864.2 мянган төгрөгөөр дутуу зөрүүтэй байна.

Нийт зардлын 2,080,204.6 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 839,095.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 42,406.0 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 190,731.7 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээс, 166,000.0 мянган төгрөгийг сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн.

Гүйцэтгэлээр 2,786,701.5 мянган төгрөгийг урсгал зардалд, 114,169.6 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 166,000.0 мянган төгрөгийг эргэн төлөгдөх зээлийн зардалд, нийт 3,066,871.1 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 83,307.0 мянган төгрөгийг аймгийн төсөвт, 51,649.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,678,122.6 мянган төгрөг буюу 94,7 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд санхүүгийн нэгтгэсэн тайланд 353,641.6 мянган төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн, бараа, ажил үйлчилгээний зардалд 223,788.5 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг буюу нэг удаагийн мөнгөн тэтгэмж, дэмжлэг, урамшуулалд 129,853.1 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 12,276.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Баянчандмань сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсөвт байгууллагууд, тусгай зориулалттай сангуудын санхүүгийн тайлангийн аудитын талаар:

- Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудиторуд нь тус сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд зөрчилгүй дүгнэлт гаргаж, ИТХ, Соёлын төв, ОНХС, СХС, Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан, тайланг түүвэрт хамруулан шалгасан. Аудитаар ЗДТГ 65,198.5 мянган төгрөгийн 2 албан шаардлага, ИТХ 4,013.8 мянган төгрөгийн 3 албан шаардлага, ОНХС 55,534.7 мянган төгрөгийн 1 зөвлөмж, СХС 7,414.1 мянган төгрөгийн 1 албан шаардлага 6,640.3 мянган төгрөгийн 1 зөвлөмж, Соёлын төв 1,499.6 мянган төгрөгийн 2 албан шаардлага тус тус өгөгдсөн байна.
- Төв аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний үндсэн дээр Дундманхайдай аудит ХХК аудит хийж, ЕБС, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв гэсэн 3

байгууллагын санхүүгийн тайланд зөрчилгүй дүгнэлт гаргаж, эргэлтийн эмийн сангийн тайланг түүвэрт хамруулан шалгасан. Аудитаар ЕБС-ийн санхүүгийн тайланд 886.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 133,334.1 мянган төгрөгийн 4 зөвлөмж, Цэцэрлэгийн санхүүгийн тайланд 1,226.3 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 50,213.9 мянган төгрөгийн 3 зөвлөмж, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд 6,747.9 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 58,093.7 мянган төгрөгийн 4 зөвлөмж, Эргэлтийн эмийн сан 32,820.3 мянган төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Баянчандмань сумын ИТХ-ын Хуралдааны 2021 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор тодотгон баталсан 3,276,031.8 мянган төгрөгийн төсвийг Төсвийн гүйцэтгэлийн тайланд 3,276.0 мянган төгрөгөөр буюу ИТХ-ын батлагдсан төлөвлөгөөнөөс тусгай зориулалтын шилжүүлэг 23,062.9 мянган төгрөг, ЭМДС 42,406.0 мянган төгрөг, ОНХС 55,864.2 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа зөрчлийг ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд тодруулах шаардлагатай байна.

Аж ахуй нэгж, байгууллагын тодорхойлолтыг Татварын албанаас гаргуулан цалин хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татвар болон Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан татварын тооцооллыг тулгахад сумын ИТХ 834.2 мянган төгрөг дутуу, Соёлын төв 49.2 мянган төгрөг, Цэцэрлэг 121.1 мянган төгрөг, ЗДТГ 7,524.1 мянган төгрөгөөр тус тус илүү зөрүүтэй байна. Орон нутгийн татварын орлогын тооцооллыг тухай бүрд хийдэггүйгээс аж ахуй нэгж, байгууллагын тодорхойлолтоор илүү, дутуу үлдэгдэлтэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд мэдээлбэл зохих 152 мэдээллээс хугацаа хоцроосон 3, огт байршуулаагүй 1 мэдээлэл байгаа нь нийт мэдээллийн 2,6 хувийг эзэлж байна. Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд нягтлан бодогчийн мэдээллийг солиогүй, төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг мэдээлээгүй, дараа жилийн төсвийн төсөл болон ТЕЗ-ийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн тоон болон чанарын үзүүлэлтийг мэдээлээгүй, хяналт шалгалтын тайланг байршуулаагүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 6 зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 01/174 дугаар албан бичгээр ирүүлсэн ба шилэн дансны мэдээллийг үнэн зөв гүйцэд байршуулах гэсэн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, татварын тодорхойлолтоор байгаа өр авлагын үлдэгдлийн тохируулаагүй зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн татварын болон татварын бус орлогыг зөрүүтэй мэдээлж буй зөрчлийг таслан зогсоосон эсэх болон ковидын зарцуулалтыг дараагийн аудитаар анхаарал хандуулах зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 153,405.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 67,918.6 мянган төгрөгийн алдааг залруулж, 2,262.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 6,696.7 мянган төгрөгийн албан шаардлага, 76,527.9 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

Аудитаар нийт 153,405.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 67,918.6 мянган төгрөгийн алдааг залруулсныг хасаж залруулагдаагүй 85,486.6 мянган төгрөгийн алдаанаас 45,479.7 мянган төгрөгийн материаллаг алдаа, 40,006.9 мянган төгрөгийн материаллаг бус алдаа бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшин 48,420.7 мянган төгрөгөөс материаллаг алдааны дүн хэтрээгүй тул зөрчилгүй санал дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Төсөвт байгууллагуудын татварын өр авлагын тодорхойлолтыг татварын цахим системээр гаргахад төсвийн нийт 6 байгууллагад 14,889.6 мянган төгрөг дутуу, 79,470.6 мянган төгрөг илүү үлдэгдэлтэй гэж тайлагнасан нь ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн татварын өр, авлагын үлдэгдэлтэй тохирохгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, 20 дугаар зүйлийн 20.2.7-д “аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Үр дүнгийн тайлан дахь үнэ төлбөргүй орлогыг бараа материалын тодруулга тайлантай тулган шалгахад 3,337.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д

“Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

Газар эзэмших, ашиглах эрх шилжилтийн бүртгэлийг эрхийн шимтгэлийн орлоготой тулган шалгахад 39 иргэний 163,450.7 мянган төгрөгийн газар эзэмших, ашиглах эрх шилжүүлсний орлогод ногдуулах 16,450.1 мянган төгрөгийн татварын орлогоос 7,660.5 мянган төгрөгийг хуулийн дагуу чөлөөлж, 6,295.2 мянган төгрөгийг 2021 онд, 127.4 мянган төгрөгийг 2022 онд төлж 2,262.0 мянган төгрөг төлөгдөөгүй үлдэгдэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.4-д “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5.-д “хариуцлагатай байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.4-д “төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй” бол төлбөрийн акт тогтоох гэсэн дагуу шийдвэрлэв.

4.3 Албан шаардлага

Орон нутгийн орлогын ойн төлбөр 645.0 мянган төгрөгөөр буюу 12,4 хувиар, ТТАМ ашигласны төлбөр 3,769.4 мянган төгрөг буюу 12.6 хувиар, хог хаягдлын татвар 917.6 мянган төгрөг буюу 5,9 хувиар, ТГӨО 114.6 мянган төгрөг буюу 45.9 хувиар, ус ашигласны төлбөр 1,250.0 мянган төгрөг буюу 100,0 хувиар нийт 5 нэр төрлийн татварын орлого 6,696.7 мянган төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д “Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ”, 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “оршин байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.5-д “төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн” бол албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. *Татварын мэдээ гаргалттай холбоотой асуудал*

1.1. Илрүүлэлт:

Орон нутгийн орлогын мэдээ нь аймгийн Татварын хэлтэс 517,302.3 мянган төгрөг, татварын улсын байцаагч 519,638.9 мянган төгрөгөөр тайлагнаж 2,336.6 мянган төгрөгөөр зөрүүтэй мэдээлсэн байна. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн орлогыг дансны хуулгатай тулгахад түрээсийн орлого 449.6 мянган төгрөгөөр илүү, ТГӨО 135.4 мянган төгрөг, бусад орлого 314.2 мянган төгрөгөөр дутуу тус тус зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн татварын болон татварын бус орлогын мэдээлэхдээ орлогын дансны хуулгыг боловсруулан үнэн зөв мэдээлж байх ба түүнд тавих хяналтыг сайжруулах

2. *Төсвийн төлөвлөлтэй холбоотой*

2.1. Илрүүлэлт:

Сумын ИТХ-ын 2021 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор Сумын татварын орлого 163,797.0 мянган төгрөг, татварын бус орлого 261,050.0 мянган төгрөг, нийт 424,847.0 мянган төгрөгөөр баталсан. Тодотгосон төлөвлөгөөнөөс нэгтгэсэн тайлангийн орлогын гүйцэтгэлийн тайланд төлөвлөгөө нь ТГӨО 250.0 мянган төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайланд ТЗШ-ийн байгууллагын санхүүжилт 23,062.9 мянган төгрөг, ОНХС-ийн санхүүжилт 55,864.2 мянган төгрөгөөр дутуу, ЭМД-ын санхүүжилт 42,406.0 мянган төгрөгөөр илүү зөрүүтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 41 дүгээр зүйлийн 41.1-д “Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хурлаас ирүүлсэн тогтоолд орлогын шилжүүлгийн дүн зөрүүтэй алдаатай тогтоолыг засуулж зөрчлийг давтан гаргахгүй байх

2.2. Илрүүлэлт:

Сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 02 дугаар тогтоолоор 2021 оны төсвийн жилд зарлагын нийт хэмжээг 3,145,355.9 мянган төгрөгөөр баталсныг ИТХ-ын 2021 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор тодотгон зардлыг 3,110,031.8 мянган төгрөг, СХС-аас олгох зээл 166,000.0 мянган төгрөгөөр, нийт зардал 3,276,031.8 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна. ТТЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланд зардлын төлөвлөгөөг 36,521.1 мянган төгрөгөөр дутуу зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь ЕБС 19,343.1 мянган төгрөгөөр илүү, ОНХС 55,864.2 мянган төгрөгөөр дутуу зөрүүтэй тайлагнасан

Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

холбоотой байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 41 дүгээр зүйлийн 41.1-д “Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хурлаас ирүүлсэн тогтоолд орлогын шилжүүлгийн дүн зөрүүтэй алдаатай тогтоолыг засуулж зөрчлийг давтан гаргахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс								Дүгнэлтийн хэлбэр
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	
1	Баянчандмань Засаг дарга	7	153,405.2	2	67,918.60	1	2,262.0	1	6,696.7	3	76,527.9	Зөрчилгүй
ТТЗ-ийн дүн		7	153,405.2	2	67,918.6	1	2,262.0	1	6,696.7	3	76,527.9	
2	Баянчандмань сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	3	4,013.8	-	-	-	-	3	4,013.8	-	-	Түүвэр
3	Баянчандмань сумын Засаг даргын Тамгын газар	2	65,198.5	-	-	-	-	2	65,198.5	-	-	Зөрчилгүй
4	Баянчандмань сумын Соёлын төв	2	1,499.6	-	-	-	-	2	1,499.6	-	-	Түүвэр
5	Баянчандмань сумын Хүн эмнэлэг	7	64,841.6	1	-	-	-	2	6,747.9	4	58,093.7	Зөрчилгүй
6	Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургууль	5	134,220.5	-	-	1	886.4	-	-	4	133,334.1	Зөрчилгүй
7	Баянчандмань сумын Хүүхдийн цэцэрлэг	6	51,440.3	-	-	3	1,226.3	-	-	3	50,214.0	Зөрчилгүй
ТШЗ-ийн дүн		25	321,214.3	1	-	4	2,112.8	9	77,459.8	11	241,641.8	
8	Баянчандмань сумын ОНХС	1	55,534.7	-	-	-	-	-	-	1	55,534.7	Түүвэр
9	Баянчандмань сумын Сум хөгжүүлэх сан	2	14,054.3	-	-	-	-	1	7,414.1	1	6,640.3	Түүвэр
10	Баянчандмань сумын БНСБС	-	-	-	-	-	-	-	-	-	-	Түүвэр
11	Баянчандмань сумын Эргэлтийн эмийн сан	4	32,820.3	-	-	-	-	-	-	4	32,820.3	Түүвэр
ОНТС-ийн нийт дүн		7	102,409.3	-	-	-	-	1	7,414.1	6	94,995.2	
Нийт дүн		39	577,028.8	3	67,918.6	5	4,374.8	11	91,570.6	20	413,164.9	

